



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 10 сарын 18 өдөр

Дугаар 446

Мандалговь

Захирамж хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Адаацаг сумын Засаг даргын 2016 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн А/33 дугаар захирамжаар өвөлжөө, хаваржааны зориулалтаар хавсралтад заасан иргэдэд газар эзэмшүүлэхдээ Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтыг үндэслэсэн нь иргэдэд өвөлжөө, хаваржааны зориулалтаар газар эзэмшүүлэх үндэслэл болохгүй байгаа тул Адаацаг сумын Засаг даргын 2016 оны А/33 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

Хоёр. Энэхүү захирамжийг Адаацаг сумын Засаг дарга (Ж.Батхөлөг)-т хүргүүлэхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Э.Чагнаадорж)-т, хавсралтад заасан иргэдэд хүргүүлэхийг Адаацаг сумын Засаг дарга (Ж.Батхөлөг)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

438010426